

Түүх 9 :
Алдагдсан хонь

Библийн эшлэл
[Лук 15:7]

Би та нарт хэлье. Мөн үүний адил, гэмших шаардлагагүй ерөн есөн зөвт хүнээс илүүгээр гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно.

Хүмүүс Есүсийн үгийг сонсохыг их хүсэмжилдэг байв.

Тиймээс ч Есүсийн явсан газар бүрд олон хүмүүс цуглардаг байлаа.

Гэвч Есүсийг нүгэлтнүүдтэй хамт байдгаас нь болж Түүнд дургүйлхдэг хүмүүс ч олон байв.

Тийм болхоор Есүс тэдэнд зориулж нэгэн сургаалт зүйрлэлийг ярьж өгөв.

Эрт дээр үед нэг хоньчин зуун хоньтой байжээ.

Энэ хоньчин хонио хайрлаж, асарч халамжилдаг байв.

Бэлчээрээсээ гэртээ харих цаг болоход хоньчин хонио тоолж гэнэ.

Тэрээр хонио дахин дахин тоолсон ч ерөн есөн хонь байв.

Хоньчин алга болсон нэг хониндоо маш ихээр санаа зовж энэ тэрүүгээр явж хайсаар байв.

Нэг мэдэхэд гадаа тас харанхуй болсон байв.

Харин хоньчин хонио хайсаар явахдаа үсэнд унаж, бүдэрч, хүндхэн замыг түүлж байсан ч шантралгүйгээр үргэлжлүүлэн хонио хайсаар байв.

Гэтэл яг тэр үед!! Намуухан чимээ дуулдав.

Хоньчин чимээ гарсан зүг рүү хамаг хурдаараа гүйв.

Чимээ гарсан зүгт яваад очтол алдагдсан хонь хадны эрмэгт зүүгдэн, бүх бие нь норж, даарч хөрсөн, айж чичирсэн байж байв.

Хоньчин хонио авраад, мөрөндөө мөрлөн гэрлүүгээ баяртайгаар буцав.



Хоньчин гэртээ хүрч ирээд чанга дуугаар хайрт эхнэр болон хүүхдүүддээ ингэж хэлэв.

“Би олчихлоо, алдагдсан хонио олчихлоо!!! Ойр хавийн хүмүүсийг бүгдийг нь дуудаж найр хийнэ ээ”

Есүс хүмүүст ингэж айлдав.

“Та нар ч мөн адил нэг хонио алдчихаад хайж олбол баярлахгүй гэж үү?

Бурхан ч бас нэг хүн гэмшээд Бурхан руу эргэж ирвэл үнэхээр их баярлах болно.

Бурхан хэнийг ч алдахыг хүсдэггүй.” гэв.

Есүс хоньчин болон хонины талаарх бас нэгэн өөр сургаалт зүйрлэлийг ярьж өгөв.

“Сайн хоньчин бол хонио мэддэг.

Хонь ч хоньныхоо дууг таньж, Түүнийг дагадаг.

Харин хонь нь танихгүй хүн хараад зугтдаг бол сайн хоньчин хэзээ ч зугтдаггүй бөгөөд араатан амьтан хоньдыг нь барихаар ирвэл араатан амьтадтай тулалддаг.

Сайн хоньчин бол хонио ямагт хамгаалдаг билээ.”

Есүс Өөрийнхөө хоньдийг хамгаалахын тулд Өөрийн амиа өгөх талаар айлдсан юм.

● Дараах библийн эшлэлийг дуурайж бицээд цээжлээрэй. (Лук 15:7)

Гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр
болох болно.





Бүтээлч байцгаая 2. Алдагдсан хонин дээр хөвөн нааж бүтэн болгоорой.

